

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС (Товч лавлах)

Б. Балдоо

Оросын Холбооны улс (ОХУ) буюу Орос улс Европ тивийн дорнод хэсэг, Ази тивийн умард хэсэгт оршино. 17075,4 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутагтай. 148,8 сая (1992. 01 01-ийн урьдчилсан тоогоор) хүн амтай. 82,6 хувь нь (1979 оны тоо бүртгэлээр) орос үндэстэн. Орос оронд 100 гаруй ястан амьдардаг.

ЗСБНХУ 1991 оны эцсээр задран унахад бүрэлдүүнд нь багтаж байсан 15 холбооны бүгд найрамдах улс тусгаар тогтносон улсууд болсны нэг нь Оросын Холбооны улс юм. Оросын Холбооны улс 1991 оны 12 дугаар сард байгуулагдсан Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн. Оросын Холбооны улсын Ардын депутатын VI их хурал (1992. IV) улсын хуучин «ЗСБНХОУ» гэсэн нэрийг өөрчилж «Оросын Холбооны улс» (ОХУ), «Орос улс» гэсэн хоёр албан ёсны нэртэй болгохоор тогтжээ. Орос улсын бүгд найрамдах улсууд, автономит улсууд, хязгаарууд, мужууд, Москва, Санкт-Петербург хотуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурсан Холбооны гэрээг VI их хурлаар батлав. Энэхүү баримт бичиг нь Орос улсын Үндсэн хуульд тусгай хэсэг (бие даасан бүлэг) болж орох юм. Орос улсын төрийн дээд байгууллага нь ОХУ-ын Ардын депутатын их хурал бөгөөд байнгын ажиллагаатай хууль тогтоох байгууллага нь түүнээс сонгогдсон Бүгд Найрамдах улсын зөвлөл, Үндэстний зөвлөл гэсэн хоёр танхимтай ОХУ-ын Дээд Зөвлөл юм. ОХУ-ын төрийн тэргүүн нь ерөнхийлөгч болно.

Оросын Холбооны улсын бүрэлдүүнд 20 бүгд найрамдах улс (өмнө нь автономит бүгд найрамдах улс, автономит муж байсан), 1 автономит муж, 10 автономит тойрог, 6 хязгаар, 49 муж, 1000 гаруй хот, 2000 гаруй хот маягийн суурин бий. Оросын Холбооны улсын нийслэл нь Москва хот (9 сая хүн амтай)

Орос орны Европ дахь нутгийн ихэнхийг өмнүүр, баруун хойгуураар Кавказын нуруу ба Хибины уулсаар хүрээлэгдсэн Дорнод европын тал эзэлнэ. Уралаас дорно зүгт өмнүүрээ Алтайн уулсаар эмжигдсэн Өрнөд Сибирийн тал, Енисей ба Лена мөрний завсарт өмнөд биеэрээ өрнөд, дорнод Саяны уулс бүхий Дундат Сибирийн өндөр тэгш газар. Лена мөрөн ба Номхон дөлгөөн далайн завсарт Зүүн хойт Азийн уул нуруу болон өндөр тэгш газар оршино. Цаг агаар нь далайн (Баруун хойт захын хязгаарт), эрс тэс эх газрын (Сибирьт) муссоны (Алс Дорнодод) гэх зэргээр хувиран солигдож, нэгдүгээр сард -1°C -аас -50°C , долдугаар сард $+1^{\circ}\text{C}$ -аас $+25^{\circ}\text{C}$ болон хэлбэлзэж, жилд 150-аас 2000 мм тунадас бууна. Ижил, Умард Двина, Дон, Печора, Обь, Иртыш, Енисей, Ангар, Лена, Амар зэрэг их мөрөн, Каспи, Байгал, Ладога, Онега зэрэг их нууртай. Газрын хэвлдэнд нефть, байгалийн хий, нүүрс, төмрийн хүдэр, апатит, калийн давс, фосфорит, өнгөт-ховорүцэт металлийн хүдэр, алмас зэрэг баялагтай.

Орос улсын нутаг дээр ангит нийгэм нэгдүгээр мянган жилийн хоёрдугаар хагаст үүсч феодалын харилцаа тогтох үйл явц удаан үргэлжилжээ. Киевын Орост эртний нэгдмэл орос ястан (IX—XII зүүнд) бий болж, энэ үндсэн дээр орос, украина, беларуссийн ард түмнүүд (XIII—

XV зуунд) бүрэлджээ. Москваг хүрээлэн Оросын төвлөрсөн улс (XIV—XVI зуунд) байгуулагдаж, 1721 онд Оросын эзэнт улс тогтов. Орос улс олон үндэстний улс (XVI—XVII зуунд) болж Ижил хавийн, Уралын, Сибирийн ард түмнүүдийг нэгтгэсэн ба Украина Оростой (XVII зуунд) дахин нэгдэв. Оросын ард түмэн XIII зуунд швед ба германы, татар-монголын, XVII зуунд польш-литва ба шведийн, Наполеоны халдлага, түрэмхийлэлд нэрвэгдэж байжээ. Феодал-хамжлагын дарлал хүчтэй болсны улмаас тариачны их дайнууд (XVIII—XIX зуунд) гарав. I Петр хааны шинэтгэл улс орны хөгжлийг урагшлуулав. Умардын дайны дунд Орос улс Балтийн тэнгист гарцтай болжээ.

Оросын хувьсгалт хөдөлгөөн Декабристуудын босолгоор (1825. Г. 14) эхлэв. 1861 оны тариачны шинэтгэл хамжлагат ёсыг халж, капитализмын хөгжлийг түргэсгэв. 1883 онд оросын анхны марксист байгууллагууд үүсч, 1898 онд ОАСДН байгуулагдаж, хожмоо ЗХУКН гэж нэрлэгдэх болов. Орос орон XX зууны эхний хориод жилд гурван хувьсгалын үеийг өнгөрөөв. 1917 оны 10-р сарын 25 (11-р сарын 7)-нд В. И. Лениний манлайлсан коммунист намын удирдлагаар ялсан социалист хувьсгалын дүнд ЗСБНХОУ байгуулагдаж дараа нь (1922. 12. 30) ЗСБНХУ-ын бүрэлдүүнд оржээ. Оросын ард түмэн холбооны бусад бүгд найрамдах улсын ард түмний хамтаар 1941—1945 онд фашист Германий эсрэг эх орны их дайнд ялалт байгуулж, улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалжээ.

Оросын ард түмэн Октябрийн хувьсгалаас хойш социалист нийгэм байгуулахын төлөө олон арван жилийн тэмцэл хийжээ. Энэ тэмцлийн жилүүдэд социалист үнэт зүйлсийг багагүй бүтээж, нийгэм-эдийн засгийн талаар их ололт амжилт олсон боловч мөнхүү үйл явц нь социалист үзэл санаа, түүний зарчмуудыг ноцтой гажуудуулсан, нийт хүн төрөлхтний соёл иргэншлийн дэвшлээс хол хөндий, өрөөсгөл нөхцөлд явагджээ. Энэ нь сталинизмийн ноёрхлын үед улс орны дотор тогтсон ганцаар захиран тушаах улс төр-үзэл суртлын систем, эдийн засагдахь төвлөрсөн төлөвлөгөөт аж ахуйн системийн үр дагавар байв. Яваандаа энэ систем мухардалд орсны улмаас түүнийг задлан өөрчилж, үндсээр шинэчлэх түүхэн шаардлага гарсан байна. Энэ үндсэн дээр 80-аад оны дундуур ЗХУКН-ын санаачилгаар зөвлөлт орон, түүний дотор ЗСБНХОУ-ын нийгмийн бүх амьдралын хүрээнд өөрчлөн байгуулалт эхэлжээ. Энэ үйл явц өнгөрсөн жилүүдэд шинэ үйл явдал, үзэл санаагаар баяжиж, шинэ шатанд оров. Түүний тулгуур суурь нь эдийн засгийн радикал өөрчлөлт буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явдал болж байна.

Оросын Холбооны улсын эдийн засаг дал гаруй жил хөгжихдөө ихээхэн потенциалыг хуримтлуулжээ. 1979 оны тоо бүртгэлийн мэдээгээр тус улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 1940 оныхоос 18 дахин өсчээ. Тус улс 1986 онд нефть (хийн конденсатын хамт) 561 сая тонн (гол төлөв Баруун Сибирь, Ижил-Уралын сав газарт), байгалийн хий 535 тэрбум м³, нүүрс 405 сая тонн (ихэнхдээ Кузбасс, Печор, Канско-Ачинск, Өмнөд Якутын сав газарт), төмрийн хүдэр 89 сая тонныг (гол төлөв Курск, Урал, Баруун Сибирьт) олзворлож байсан бөгөөд 1001 тэрбум кВт цагийн эрчим хүчийг голдуу дулааны, мөн түүнчлэн усан ба атомын цахилгаан станцаар боловсруулан гаргаж байлаа. Орос улсад хар төмөрлөг (Магнитогорск, Челябинск, Доод Тагил, Новокузнецк, Череповец, Липецк зэрэгт) ба өнгөт төмөрлөг (Норильск, Красноярск, Эрхүү зэрэгт), хими ба нефтехимийн аж үйлдвэр, алмасын (Якут) баялаг орд газар, машин бүтээх үйлдвэрлэл (Москва, Санкт-Петербург, Урал, Ижил хавийн нутаг, Баруун Сибирьт), барилгын материалын болон хөнгөн, хүнсний аж үйлдвэр хөгжсөн ажээ.

Орос улс эдийн засгийн хямралд автагджээ. Ихэд монопольчлогдсон аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн жилүүдэд буурч байна. Хямралыг даван туулахын тулд Оросын Холбоот улсын Засгийн газар улсын өмчийг задлах, хувийн бизнесийг дэмжих, эдийн засагт төрөөс оролцох явдлыг багасгах зэргээр эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх бодлого явуулж байна. 1991 онд хувийн болон хамт олны өмчид 2 тэрбум орчим рублийн үнэтэй (127 худалдаа, нийтийн хоолны, 47 ахуй үйлчилгээний 500 аж үйлдвэрийн газар зэрэг) төрөл бүрийн объектыг шилжүүлсэн байна. 1992 оны 1 дүгээр сарын 1-ээс улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах программ батлагдав. 1992 онд хувьчлагдах газруудын голыг 250 хүртэл ажиллагсадтай 10 мянга гаруй улсын үйлдвэрийн газар эзлэхээр төлөвлөгдөж байна.

1992 оны эхэнд 80 мянга гаруй аж ахуйн шинэ бүтэц бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн дотор 65 мянга орчим янз бүрийн нөхөрлөл, 8,9 мянган хувь нийлүүлсэн нийгэмлэг, 3,1 мянган ассоциаци, 227 концерн, 189 холбоо, 123 консорциум, 1,3 мянган арилжааны банк, 110 гаруй бирж байгаа болно. Гэвч зохион байгуулалтын эдгээр шинэ бүтцүүд нь үйлдвэрлэлд урагш түлхэх нөлөө хараахан үзүүлдэг болоогүй байна.

Оросын Холбооны улсын хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 1984 онд 1940 оныхоос 2,6 дахин өсч, 1986 онд тариа ногооны талбай 119,2 сая га (1940 онд 92,1 сая га) болжээ. Газар тариалангийн гол бүтээгдэхүүн болох үр тариа 1991 онд 89,1 сая тонн, чихрийн манжин 24,4 сая тонн, наран цэцгийн тос 2,9 сая тонн, төмс 34,0 сая тонныг тус тус хураан авчээ. 1991 онд улсад худалдсан үр тарианы хэмжээ (22,5 сая тонн) нь сүүлийн 25 жилд хамгийн бага байв. Мал аж ахуйг мах, сүү, ноосны чиглэлээр хөгжүүлдэг. 1991 онд үхэр 42,3 сая (1987 оны эхээр 60,5 сая), гахай 24,4 сая (1987 онд 40,2 сая), хонь, ямаа 37,4 сая (1987 онд 64,1 сая), тахиа, шувуу 442,5 сая байжээ. 1986 онд 12,1 мянган хамтрал, 12,5 мянган сангийн аж ахуй байжээ. Орос улсын Засгийн газраас хөдөө аж ахуйг хөтлөн явуулахад зориулан иргэдэд газар олгох болсон бөгөөд 1991 онд нийт 10 гаруй сая өрх айлд ногооны болон хамтын цэцэрлэгийн газар олгов. 1991 оноос газрын шинэтгэл эхэлж мөн оны эцэст 50 мянган тариачны (фермерийн) аж ахуй байгуулагдав.

Орос улс 1986 онд 85,3 мянган километр урт төмөр зам, 832,7 мянган километр авто зам, Беломор-Балтийн, Москвагийн, Ижил-Доны суваг, Ижил-Балтийн усан зам зэрэг усан замын систем, газар доорхи яндан хоолойн сүлжээтэй байв.

Оросын Холбооны улсын экспорт 1991 онд 64,2 тэрбум гадаад валютын рубль болж, нефтийн экспорт 54,5 сая тонн (1990 оныхоос 2 дахин бага), байгалийн хийнийх 89,6 тэрбум м³ (1990 оныхоос 7 хувь бага) болжээ. Экспортын 67 хувь нь Европод, 27 хувь нь Азид, 4 хувь нь Америк гарсан байна. Тус улсын импорт 1991 онд 44,7 тэрбум гадаад валютын рубль болсон нь 1990 оныхоос 45 хувь хорогджээ. Импортын 45 хувийг машин, тоног төхөөрөмж, 18 хувийг өргөн хэрэгцээний бараа эзэлж байсан бөгөөд импортын барааны 58 хувь нь Европоос, 20 гаруй хувь нь Азиас, 18 хувь нь Америкаас ирсэн байжээ. 1991 онд гадаад орнуудаас хүмүүнлэг тусламжийн шугамаар 32,7 мянган тонн бараа иржээ.

Улс орны эдийн засагт 1991 онд 135,7 сая хүн ажиллаж байсны 98,9 сая нь улсын үйлдвэр, байгууллагуудад, 12,7 сая нь түрээсний, хувь нийлүүлсэн, концерн нэгтгэлийн, олон нийтийн (фондын), хамтарсан үйлдвэрийн зэрэг газруудад, 17,6 сая нь хамтрал хоршооллын секторт, 6,5 сая нь хувийн болон амины аж ахуйд тус тус ажиллаж байв.

Сүүлийн жилүүдэд хөдөлмөрчдийн амьжиргааны индекс байнга өсч, мөнгөний ханш унаж, ажилгүйдэл нэмэгдэж байна. 1991 онд хэрэглээнй барааны үйлдвэрлэл 9 хувь хорогдож, амьжиргааны өртөг 25 хувиар өсөв. 1992 оны эхэнд Оросын ажил олгох улсын албанд 60 мянган ажилгүйчүүд бүртгэгдсэн бөгөөд 110 мянган хүн ажил сураглаж, үйлдвэр, албан газраас 850—900 мянган өргөдөл иржээ.

1991—1992 оны хичээлийн жилд гүнзгийрүүлсэн сургалттай 6,8 мянган сургуульд 3,9 сая сурагчид, 306 гимназид 219 мянган сурагч, 198 лицейд 115 мянган сурагч, 85 хувийн сургуульд (1991. 12. 1) 6,7 мянган хүүхэд; 519 их, дээд сургуульд 2,8 сая оюутан, 2,6 мянган тусгай мэргэжлийн дунд сургуульд 2,2 сая оюутан тус тус суралцаж байлаа. 1991 онд улс ардын аж ахуйн салбаруудад дээд сургуулиас 406,8 мянган мэргэжилтэн, техникумаас 623,2 мянган мэргэжилтэн бэлтгэн гаргажээ.

80-иад оны дундуураас олон улсын үйл хэрэгт хандах шинэ хандлагыг боловсруулж, түүнийг орчин үеийн дэлхий дахины бодит байдалд тохируулснаар ЗХУ-ын гадаад бодлого шинэ шинж чанартай болжээ. Эдгээр хандлага нь юуны өмнө хүйтэн дайныг дуусвар болгох, улс орныг цэрэгжүүлэн зэвсэглэлийн хойноос хөөцөлдөх явдлыг зогсоох, бусдын хэрэгт оролцон улс орныхоо хилийн гадна цэрэг ашиглахаас татгалзах, улс төрийн бодлогоо дэлхий дахинд нээлттэй болгож, олон улсын асуудлыг улс төрийн аргаар, яриа хэлцлийн аргаар шийдвэрлэх зэрэгт илэрлээ олсон юм. Зөвлөлт Холбоот улс оршин тогтнохоо больсны дараа тэрхүү бодлогыг үргэлжлүүлэгч нь Оросын Холбооны улс болсон юм. Иймээс ч Оросын Холбооны улсын гадаад бодлого сүүлийн жилүүдэд ЗХУ-ын явуулж ирсэн гадаад бодлогоос эрс ялгагдахгүй гэж ОХУ-ын ГЯЯ-ны сайд мэдэгдээд Оросын гадаад бодлогын хоёр гол чиглэл нь дотоодод явуулж буй шинэтгэлийн гадаад нөхцөлийг хангах, ардчилсан төр улсаа дэлхий улсуудын хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүнд оруулах явдал мөн гэж тэмдэглэжээ. Орос улсын Засгийн газар өөрийн боловсруулсан үзэл баримтлалын дагуу идэвхитэй гадаад бодлого, олон улсын өргөн хамтын ажиллагаа явуулж байна.

Монгол, Орос хоёр улс 1921 онд дипломат харилцаа тогтоож, олон жилийн туршид сайн хөршийн холбоо хэлхээтэй явж иржээ.

Монгол улс, Оросын Холбооны улс хоёрын аль алинд өөрчлөн байгуулалтын үйл явц өрнөж буй өнөөгийн нөхцөлд хоёр орны харилцааг шинэ шатнаа гаргах, тэгэхдээ урьдаас уламжлагдан ирсэн найрсаг хэлхээ холбооны хүрээн дотор тэгш эрхт түншүүдийн харилцаа болгон өөрчилж, түүнийг зохицуулах гэрээ-эрхийн үндсийг шинэчлэх хэрэгтэй болсон юм. 1991 оны эхээр Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай Монгол-Оросын Тунхаглалыг гаргасан бөгөөд түүнийг үндэслэн хоёр орны худалдааны хэлэлцээр, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комисс тус тус байгуулсан билээ. Тунхаглалд хил залгаа муж, улстай харилцааг хөгжүүлэхийг заасан дагуу 1991 оны эцэс, 1992 оны эхээр Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Буриад Улсын төлөөлөгчид манай оронд айлчилж, хамтын ажиллагааны асуудлаар хэлэлцээ хийж, баримт бичгүүдэд гарын үсэг зурсан байна.

1992 оны 3 дугаар сард Монгол улсын Ерөнхий сайд Оросын Холбооны улсад ажлын айлчлал хийж мөн улсын зарим удирдах нөхөдтэй хэлэлцээ хийж Протокол гаргажээ. Протоколд Монгол улс, Оросын Холбооны улсын хоорондын шинэ гэрээ байгуулж гарын үсэг зурах ажлыг түргэвчилэх, Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг

жил тутам хийж байх, 1992 оны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээг дуусгаж, Засгийн газар хоорондын Протокол төлбөрийн болон банк хоорондын хэлэлцээрт үсэг зурахаар тохиролцожээ. Уулзалтын үеэр эдийн засгийн харилцааны бүтэц, механизмыг боловсронгуй болгох, түүний дотор асуудлыг аж ахуйн төвшинд шийдвэрлэх харилцааны механизмыг бий болгоход анхаарлаа хандуулав. Хоёр тал хил худалдаа, дамжин өнгөрөх тээвэр, хөрөнгө оруулалт, давхар татвар зэрэг асуудлаар хэлэлцээр байгуулах; нүүрс, барилга зэрэг салбарт хамтарсан үйлдвэр байгуулах, нефтийн бүтээгдэхүүн, зэсийн баяжмалыг харилцан нийлүүлэх; зарим газар чөлөөт бүс байгуулах; өрийн асуудлыг зохицуулах; мэдээлэл, хэвлэлийн бүтээлийн солилцоог өргөтгөх зэрэг асуудлаар санал солилцож цаашид судалгаа хийхээр тохиролцов. Энэхүү айлчлалын үеэр Монгол улс, Бүгд Найрамдах Халимаг Тангч улсын Засгийн газрын хооронд соёл, эдийн засгийн салбарт ойрын жилүүдэд хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурсан юм.

1992 оны 6-р сард Монгол улс, Оросын Холбооны улсын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаан Улаанбаатарт болж, комиссын анхдугаар хуралдааны Протокол, хоёр улсын Засгийн газар хоорондын төлбөрийн тухай Хэлэлцээр, хоёр улсын 1992 оны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Протоколд гарын үсэг зурав. Хуралдаанаар Монгол улсад 800 мянган тонн нефть бүтээгдэхүүнийг энэ онд Орос улсаас нийлүүлэх, хуучин ЗХУ-аас Монголд барьж байгаад дутуу орхисон барилга байгууламж зэргийг дуусгахад зориулан ОХУ-аас 38,7 сая америк долларын зээл олгох болов. Эдгээр уулзалт, яриа, тохиролцоо нь хоёр орны харилцаанд хуримтлагдсан асуудлуудыг удаашруулахгүйгээр ухаалаг, ул суурьтай шийдвэрлэх, сайн хөршийн хамтын ажиллагааны эрчимтэй хөгжлийн замыг цэвэрлэхэд ихээхэн ач тустай болох юм. Монгол улс, Оросын Холбооны улсын найрсаг харилцаа, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал манай ард түмнүүдийн язгуур эрх ашигт үнэнхүү нийцэх бөгөөд нийнхүү хамтран ажиллахад тохиолдох саад бэрхшээлийг даван туулж ирсэн баялаг өв уламжлал хоёр улс, хоёр ард түмэнд бий билээ.

1. Зөвлөлтийн нэвтэрхий толь бичгийн толь (Советский энциклопедический словарь М, «Советская энциклопедия», 1986, 1140 тал, 1989, 1149—1152 тал.
2. Дэлхийн улс орон (Страны мира), Лавлах. М., Политиздат, 1989, 3—17 тал
3. Оросын Холбооны улсын 1991 оны нийгэм-эдийн засгийн байдал (Социально-экономическое положение Российской Федерации), Оросын Холбооны улсын Улсын статистикийн газрын мэдээлэл. Экономическая газета («Экономики и жизнь») № 4, 1992 оны 1 дүгээр сар.
4. Эдийн засгийн салбаруудад ажиллагсдын бүтэц (Структура занятых по секторам экономики). Экономическая газета («Экономика и жизнь») № 2, 1992 оны 1 дүгээр сар.
5. Оросын холбооны улсын улсын ба нутгийн захиргааны үйлдвэрийн газруудыг 1992 онд хувьчилах программ, гол үндэслэлүүд. «Российская газета», 1992, 01. 30.
6. Оросын холбооны улсын гадаад явдлын яамны сайд А. Қозыревын ярилцлага («Когда мы ушли от мессанства»). «Российская газета, 1992, 01, 21
7. «Ардын эрх» сонин. 1991 он, № 229, 230, 232, 1992 он, № 4, 30 31.
8. «Засгийн газрын мэдээ» сонин, 1992 он, № 19

ГЕНХИЙН ИХ СУРГУУЛЬ (БНСУ)

Генхийн их сургууль 1949 онд байгуулагдсан. Хувийн сургууль. Хүйс ялгаварлахгүй сургадаг.

Тус сургуулийн үйл ажиллагаа нь хүүхдийн цэцэрлэгээс эхлээд их сургууль төгсөгчдийг хүртэл хамаран сургадаг өргөн системийн үндсэн дээр явагддаг.

Сургуулийн уриа лозун нь Сургууль, Үзэл санаа, Ахуй амьдралын ардчилах явдал юм.

Сургуулийн эрхэмлэдэг амьтан нь арслан, өнгө нь элгэн хүрэн өнгө, цэцэг нь замбага цэцэг юм.

Их сургууль нь Сеулд 245 акр, Сувонд 510 акр, Кваннунд 12 акр газар бүхий 3 байртай.

3-р сараас 8-р сард, 9-р сараас 2-р сард үргэлжилдэг **2 семестртэй.**

16 коллежтэй. Эдгээр нь Либерал урлаг ба шинжлэх ухаан, Хууль зүй, Улс төрийн ухаан ба эдийн засаг, Хүмүүжил боловсрол, Анагаах ухаан, Дорно дахины анагаах ухаан, Шүдний эмчилгээ, Эм зүй, Хөгжим, Биеийн тамирын хүмүүжил-боловсрол, Гадаад хэл ба утга зохиол, Нийгмийн ухаанууд, Байгалийн ухаанууд, Инженерийн урлаг, Аж үйлдвэр, Биеийн тамир ба спортын коллеж болно.

Төгсөөд цааш суралцагсадын (бакалаврын зэргээс дээгүүр зэрэг хүртээдэг) **6 сургуультай.** Эдгээр нь Төгсөөд цааш суралцах сургууль, Аж ахуйн удирдлага, Олон нийтийн удирдлага, Хүмүүжил-боловсрол, Технологи ба мэдээллийн шинжлэх ухаанууд, Холбоо харилцааны сургууль бөгөөд бас төгсөөд цааш суралцах Энх тайвны судлалын 1 институттай.

1303 багш ажилладгаас 42 хувь нь орон тоогоор, 58 хувь нь хагас орон тоогоор багшилдаг.

24,000 суралцагсад байгаагаас 89 хувь нь оюутан, 11 хувь нь төгсөөд цааш суралцагсад, 3 хувь нь дотуур байранд суугчид юм. Дундач нас нь 22.

Номын санд нь 1, 000, 000 орчим номтой.

2 музейд 22 000 гаруй үзмэрийн зүйл бий.

Их сургуулийн эмнэлгийн төв нь Дорно ба Өрнө дахины эмнэлгийг хослон хэрэглэдэг.

31 эрдэм шинжилгээний хүрээлэнтэй. Эдгээр нь Олон улсын энх тайвны судлал, Брайтер нийгэмлэг, Хүмүүжил-боловсролын үйлс, Нийгмийн шинжлэх ухаан, Дорнод-өрнөдийн анагаах ухаан, Шувууны судлал, Аж үйлдвэр ба хүрээлэн буй орчны судлал, Хууль зүйн судлал, Солонгосын соёл, Кампусын хөгжил, Нарны эрчим хүч, Язгуур урлаг, Хэл бичиг, Газрын уран барилга, Эдийн засаг ба аж ахуйн удирдлагын түүх, Аж үйлдвэрийн менежмент, Аж үйлдвэрийн харилцаа, Дорно дахины эм, Хүнсний нөөцийн хөгжил, Уран барилга ба хотын судлал, Лазерийн инженерийн урлаг гэх мэт.

4 эрдэм шинжилгээний төвтэй. Эдгээр нь Хүний нийгмийг өөрчлөн байгуулахуй, Газрын хөгжил, Холбоо харилцаа, Оюутны амьдрал.

Биеийн тамирын төрлүүд: Соккер (Америкийн футбол) Регби, Сагсан бөмбөг, Бейсбол, Гандбол, Мөсний хоккей, Газрын хоккей, Теннис, Ширээний теннис, Хүндийн өргөлт, Тэквандо, Кендо, Жудо, Бокс, Хөнгөн атлетик, Дугуй, Тэшүүр, Буудлага, Гимнастик.

Амарч цэнгэх газар: Оюутны төв, Цайны газар, Гимнастикийн зал, Хөнгөн атлетикийн талбай, Дотуур байр, Театр, Мьюзик хол, Компьютерийн лабораториуд, Номын худалдаа, Эмнэлгийн төв, Аудио-Видео боловсролын төв.

Орон сууц. Оюутны дотуур байр 3, гадаадаас суралцагсадад зориулсан зочдын 1 байртай.

Дэлхийд өргөн дэлгэрсэн хөдөлгөөн: Брайтер нийгэмлэгийн хөдөлгөөн, Сайн амьдрахын төлөө хөдөлгөөн.

Их сургуулийн фестиваль: Замбага цэцгийн фестиваль, Намрын атлетикийн фестиваль.

Генхийн их сургуулийг үндэслэн байгуулагч, ерөнхийлөгч нь ноён ЧО ЕН СИК (1922. XI. 22-нд төрсөн) юм. Эдүгээ ноён Чо Ен Сик Ген-

хийн их сургуулийн системийн тэргүүн (Чанселор), Их сургуулиудын ерөнхийлөгчдийн олон улсын холбооны чөлөөнд гарсан бөгөөд насан туршдын ерөнхийлөгч, Брайтер нийгэмлэгийн хүрээлэнгийн ерөнхийлөгч, Олон улсын энх тайван судлалын хүрээлэнгийн ерөнхийлөгч, Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн ерөнхийлөгч, Хүний нийгэмлэгийг өөрчлөн байгуулах төвийн ерөнхийлөгч, Брайтер нийгэмлэгүүдийн дэлхийн хамтын ажиллагааны ерөнхийлөгч 10 сая салангид гэр бүлийг нэгтгэхийн төлөө Солонгосын Ассамблейн дарга, Их сургуулиудын ерөнхийлөгчдийн олон улсын холбооны энх тайвны төлөө Дээд Комиссийн дарга, Ази Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны олон улсын сангийн ерөнхийлөгч (Москва, ЗХУ)-ийн үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

Ноён Чо Ен Сик Сеулын Үндэсний их сургууль дүүргэж, хууль зүйн бакалаврын зэрэг 1950 онд хүртсэнээс хойш эдүгээ хүртэл олон орны, тэдгээрийн дотор АНУ, Япон, ЗХУ-ын их сургуулиас хууль зүйн доктор, утга зохиолын доктор, философийн доктор, энх тайвны философийн доктор зэрэг хүндэт зэрэг цолыг 22 удаа хүртжээ. Ерөнхийлөгч Чо 1951—1991 онд бага дунд, дээд сургууль, их сургууль, хүүхдийн цэцэрлэг, музей, дотуур байр, нийгэмлэг, сан зэрэг 30-аад байгууллага, тэдгээрийн дотор Генхийн их сургуулийн системийн байгууллагуудыг үндэслэн байгуулж, 1964—1991 онд Брайтер Нийгэмлэгийн хөдөлгөөн, сайн амьдрахын төлөө хөдөлгөөн, Солонгосын салангид гэр бүлүүдийг нэгтгэх хөдөлгөөн, НҮБ-ыг хүчтэй болгох хөдөлгөөн зэрэг үндэсний ба улсын нэлээд кампанийг санаачилжээ.

Доктор Чо Ен Сик-д 1962 оноос эдүгээ хүртэл 20-иод орны их сургууль, эрдэм судлалын газар, олон улсын байгууллага хүндэтгэлийн медаль, одон, дээд шагнал хүртээж, хотын түлхүүр гардуулж, хүндэт иргэн болгож, нэрэмжит танхим бий болгох зэргээр гавьяа зүтгэлийг нь үнэлжээ. Түүнийг Монгол улсын ШУА-ийн ойн медалиар шагнаж, Зүүн хойт Ази судлалын төвийн Эрдэмийн Зөвлөлийн хүндэт гишүүн болгосон юм.

Ноён Чо 1960 онд Солонгосын их сургуулиудын оюутны төлөөлөгчдийг удирдан Зүүн өмнөд Азийн 4 орноор анх айлчилснаас хойш 20 гаруй удаа төлөөлөгчид даргалан олон улсаар айлчилж олон улсын найрамдал, энх тайвныг бэхжүүлэх, энх тайвны өдөр болон жилийг тунхаглах, энэ үйлст зориулсан тунхагууд гаргах кампани санаачлах, элдэв гамшигт нэрвэгсэдэд тусламж үзүүлэх ажил зохиосны дээр 1968—1991 онд «Сеулын тогтоол», «Манилын тунхаг», «Хүний нийгэмлэгийн шинэ тунхаглал» зэрэг 20 гаруй баримт бичгийг боловсруулан олон улсын байгууллагын гүйцэтгэх байгууллагууд, олон улсын их хурал зэргээр батлуулан тунхаглаж байв.

Ерөнхийлөгч Чо Ен Сик 1950 онд Солонгосын үндэсний ассамблейн Төлөвлөлт ба Захиргааны товчооны захиралаар томилогдохоос эхлээд улсынхаа дотоод, гадаадад өөрийн мэргэжлийн дагуу коллеж, судалгааны хүрээлэн, их сургууль, эрдэм шинжилгээ ба боловсролын холбоо, найрамдлын нийгэмлэг зэргийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, зөвлөх, гадаадын их сургуулиудад профессор, зөвлөх зэрэг 80 гаруй албан тушаалд ажиллажээ. Мөн түүнчлэн Солонгосын их сургуулиудын спортын нэлээд холбоодын ерөнхийлөгч, тэргүүлэгч гишүүн, 1988 оны Сеулын Олимпийг дэмжих хорооны гишүүнээр ажиллажээ. Ноён Чо бизнесийн үйл ажиллагаанд оролцож хэд хэдэн кампани байгуулсан ажээ.

Доктор Чо Ен Сик 1948 онд «Ардчилсан эрх чөлөө» хэмээх ном нийтлүүлснээс хойшхи 40 гаруй жилд соёл иргэншил, боловсрол, энх тайван, хүний нийгмийн хөгжил зэрэг нийтлэг асуудлаар 25 бүтээл

туурвиж, заримыг англи, япон, хятад, испани хэл дээр гаргасан байна. Дэлхийн олон оронд зохиогдсон 50 гаруй бага хурал, симпозиумд оролцон олонхийг даргалжээ. АНУ, Англи, ЗХУ, Унгар, Коста-Рико, БНХАУ зэрэг 14 улсын голдуу их сургуулиудад тусгайлсан лекцүүд уншиж байсны дотор «Гуравдугаар ардчилсан хувьсгал ба ЗХУ» лекцийг Москвагийн их сургуульд (1991), «Зүүн Азийн эрин үед Солонгос, Япон, Хятадын үүрэг» лекцийг БНХАУ-ын Ляонин мужид, «Хүйтэн дайны дараах үед АНУ-ын гүйцэтгэх шинэ үүрэг» лекцийг АНУ-ын Коннектикут муж улсын их сургуульд уншжээ. Доктор Чо 100 гаруй орноор аялахдаа дээд боловсрол, нийгэм-эдийн засгийн хамтын ажиллагаа болон эрдэм шинжилгээний уулзалт, соёлын солилцооны салбарт идэвхтэй ажил өрнүүлж байжээ.

Доктор Чо Ен Сикийн нэр дэлхийн нэрт зүтгэлтэн нарын намтрыг нийтэлдэг Энэтхэгийн 3, БНСУ-ын 5, Английн 9, АНУ-ын 5, бүгд 22 толь бичгүүдэд орсон байна.

«Kyung Hee University at Glance», ««Curriculum vitae of Dr. Young Seek Choue» материалыг үндэс болгон лавлагааг бэлтгэсэн **Б. Балдоо.**